



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

「 Хувьчлалын жагсаалтаас хасах тухай 」

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчөөс 2015, 2019 онуудад хувьчлахаар баталсан хуулийн этгээд, эд хөрөнгийн хавсралтад дурдсан барилга байгууламж, нийслэлийн өмчийн ноогдол хувийг хувьчлалын жагсаалтаас хассугай.

2.Хувьчлалын жагсаалтаас хасагдаж байгаа барилга байгууламжийн эзэмшил, ашиглалт, нийслэлийн өмчийн ноогдол хувьд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 24/05 дугаар тогтоолын хавсралтын “Хоёр.Эд хөрөнгө” гэсний 6 дугаарт, мөн оны 32/29 дүгээр тогтоолын хавсралтын 6 дугаарт, 2019 оны 29/32 дугаар тогтоолын хавсралтын “А.Хуулийн этгээд” гэсний 1 дүгээрт, “Б.Эд хөрөнгө” гэсний 1 дүгээрт туссан барилга байгууламж болон хуулийн этгээдийн хувь хэмжээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 50...  
дугаар тогтоолын хавсралт

ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ЖАГСААЛТААС ХАСАХ  
ЭД ХӨРӨНГӨ

№	Хуулийн этгээд, эд хөрөнгийн нэр	Хувьчлах талаар гарсан шийдвэрүүд	Жагсаалтаас хасах үндэслэл	Тайлбар
1	50 дугаар дэлгүүрийн өргөтгөлийн барилга	НИТХ-ын 2019 оны 29/32 дугаар тогтоол	Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төв үйл ажиллагаа явуулж байна. Тус төв нь түрээсийн гэрээ байгуулан уг объектыг ашигладаг.	Нийслэлд ашигтай, цаашид өгөөжөө өгөх үнэ цэнэ бүхий барилга
2	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын өргөтгөлийн барилга	НИТХ-ын 2015 оны 32/29 дүгээр тогтоол	Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын баланст бүртгэлтэй уг барилгад Сүхбаатар дүүрэг, Баянзүрх дүүрэг, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх үйл ажиллагаа явуулж байгаа ба тус шүүхийн Тамгын газраас, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс барилгыг эзэмшилдээ шилжүүлж авах хүсэлтийг ирүүлсэн.	Нийслэлд ашигтай, цаашид өгөөжөө өгөх үнэ цэнэ бүхий барилга
3	Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, агуулахын барилга	НИТХ-ын 2015 оны 24/05 дугаар тогтоол	Агуулахын барилга нь нийслэлийн Өмчийн харилцааны газрын баланст бүртгэлтэй боловч газрыг нь хувь иргэнд эзэмшүүлсэн шийдвэр гарсан. Газрын зөрчлийг арилгах хүсэлтийг нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.	Газрын зөрчлийг арилтал хувьчлах боломжгүй
4	"Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн нийслэлийн өмчлөлийн 49 хувь	НИТХ-ын 2019 оны 29/32 дугаар тогтоол	Үнэлгээ хийлгэхээр зөвлөхийн үйлчилгээний тендер 2 удаа зарласан боловч амжилтгүй болсон. Нийслэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхээр хууль хяналтын байгууллагад хандсан	Нийслэлийн иргэдэд үйлчилдэг, ногоон байгууламж бүхий спорт, биеийн тамирын зориулалтаар нь ашиглах